



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/220

Хэрлэн сум

Аймгийн "Хүндэт тэмдэг" хийлгэх  
зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймаг нийслэлийн Засаг даргаас олгох шагналын нийтлэг тодорхойлолт", аймгийн Засаг даргын 2003 оны А/99, 2015 оны А/511 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий нутгийн хөгжлийн төлөө онцгой амжилт гаргасан иргэдийг шагнах аймгийн "Хүндэт тэмдэг" хийлгэх зардалд 11,220,000 (арван нэгэн сая хоёр зуун хорин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайханд)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын...-ны өдрийн  
... дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Дүн
1	Хүндэт тэмдэг медаль, хавтас, үнэмлэх	600	18700	11220000
	Нийт			11220000